



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/108

Алтай хот

**Тайшир, Жаргалан сумдад ажиллах
 ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 27¹ дугаар зүйлийн 27^{1.2} дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тайшир-Гуулын усан цахилгаан станц, "Ундрага-Алтай" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын усны эх үүсвэрийн үйл ажиллагаа болон Жаргалан сумын Завхан гол дагуу айл өрхүүдэд үүссэн нөхцөл байдалтай танилцаж, үнэлэлт дүлнэлт өгөх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Есөнбулаг сумын ундны ус хангамжийн асуудал, Тайшир сумын Завхан голын гүүр, Жаргалан сумын Завхан гол болон Бүрэн багуудын айл өрхүүдийн өвөлжөө, хаваржаа орчмын мөсний тэлэлтийн нөхцөл байдалтай танилцаж, мэргэжлийн байгууллагын санал дүгнэлтийг гаргуулан аймгийн Онцгой комиссын хуралд шуурхай танилцуулж, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг (дэд хурандаа Ц.Лувсанжамц)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажлын хэсгийг ерөнхий удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2013 оны
02 дугаар сарын 14-ны өдрийн
11108 дугаар захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: д/х Ц.Лувсанжамц (Онцгой байдлын газрын дарга)

Гишүүд:

Г.Хурцгэрэл (Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

х/а Д.Төмөрбаатар (Цэргийн штабын дарга)

х/а Н.Мэндбаяр (Цагдаагийн газрын дарга)

Т.Сүхбаатар (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Д.Алтанзагас (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Г.Олонбаатар (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Ц.Ариунжаргал (Стандарт хэмжил зүйн хэлтсийн лабораторийн эрхлэгч, цахилгааны улсын шалгагч)

Б.Бээжин ("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн ерөнхий инженер)

А.Амгаланболд ("Тайшир-Гуулин" усан цахилгаан станцын инженер)

Э.Энхболд ("Ундарга-Алтай" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга)

Нарийн бичгийн дарга: х/ч Ц.Амарсанаа (Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч)